ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ

CHARACTERISTICS OF LEGAL REGULATION OF EXECUTION OF COURT DECISIONS IN SOME FOREIGN COUNTRIES CASES

Б.Батчимэг

Дотоод хэргийн их сургуулийн докторант

Товч утга: Энэхүү өгүүллээр гадаадын зарим орны шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтэц, тогтолцоо, үйл ажиллагааны онцлог, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж буй сайн туршлагыг судалж, харьцуулан авч үзсэн болно.

Түлхүүр үг: захиргааны хэргийн шүүх, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, хувийн шийдвэр гүйцэтгэгч, шериф, маршалын алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Abstract: This article examines and compares the structure, system, and operational characteristics of court decision enforcement organizations in some foreign countries, as well as the good practices of effective decision enforcement.

Keywords: Administration court, execution of court decisions in administrative case, court decision enforcement operation, sheriff, office of marshals, personal bailiff.

Улс орон бүрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь өөрийн гэсэн механизмтай байдаг. Гэхдээ аль ч орны хувьд шүүхийн шийдвэрийг богино хугацаанд, үр дүнтэй гүйцэтгэхийг зорьдог бол ялгаатай тал нь уг зорилгод хүрэх арга замаар илэрдэг. Энэ талаар Б. Хесс “улс орны шүүхийн

шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гол ялгаатай тал уг ажиллагааг хэрэгжүүлж буй салбарын тогтолцооны хэлбэр (нэгдсэн, эсвэл салангид буюу хэд хэдэн бие даасан байгууллагаас бүрдсэн)-ээс ихээхэн хамаарна.” гэжээ.

ОХУ-ын эрдэмтэн В.В. Захаровын хэлснээр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь тухайн улсын шүүхийн тогтолцооны онцлогтой нягт уялдах[1], шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтолцооны загвар нь шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэлбэр (мэтгэлцээний, мөрдөн байцаалтын, холимог) болон тухайн улсын үндэсний, соёлын, шашны онцлогтой уялдсан байх учиртай[2] гэжээ.

Хэрэгжүүлэгч субьектээр нь:

Тухайлбал, Швед Улсад Үндэсний шүүхийн шийдвэр гүйцэтгэх агентлаг нь гүйцэтгэх засаглалын байгууллага болохын хувьд шүүхийн, захиргааны, арбитрын болон бусад төрлийн шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлдэг. Үүнтэй төстэй тогтолцоотой оронд Финлянд Улс тооцогддог. Харин бусад европын улсуудын хувьд, тухайлбал, Австри, Испани зэрэг улсад шийдвэр гүйцэтгэх төвлөрсөн тогтолцоог шүүх дангаараа бүрдүүлдэг. Эдгээр орны хувьд шүүхийн байгууллагын алба хаагчид шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч талтай нягт холбоотой ажилладаг. Түүнчлэн Бельги, Нидерланд улсад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төвлөрсөн тогтолцоог хувийн шийдвэр гүйцэтгэгчид бүрдүүлдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь төвлөрсөн ба төвлөрсөн бус гэсэн хэлбэртэй. Төвлөрсөн тогтолцоо нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэг байгууллага дангаараа, харин төвлөрсөн бус тогтолцооны хувьд хэд хэдэн байгууллага хамтран хэрэгжүүлдэг. Тухайлбал, төвлөрсөн бус тогтолцоотой оронд Англи тооцогдох бөгөөд тухайн байгууллага нь тодорхой төрлийн нэхэмжлэлийг хариуцах бөгөөд мужийн түвшинд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, харин Улсын дээд шүүхийн түвшинд цагдаагийн байгууллага гардан хэрэгжүүлдэг. Санхүүгийн яам болон бусад олон нийтийн байгууллага бүр өөрийн шийдвэр гүйцэтгэх албатай бөгөөд зарим тохиолдолд уг ажиллагаанд хувийн шийдвэр гүйцэтгэгчийг татан оролцуулдаг.

Францад шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гол төлөв хувийн шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлдэг бөгөөд зарим төрлийн нэхэмжлэлийг

---

[1] Захаров В.В. Будет исполнено.

[2] См. подробнее: Решетникова И.В. Доказательственное право Англии и США.М.: Городец, 1999.

шийдвэр гаргасан шүүх хариуцдаг. Жишээлбэл, цалингийн орлогоос авах тодорхой суутгалыг доод шатны шүүхийн ерөнхий шүүгч гардан хэрэгжүүлнэ.

ХБНГУ-д шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төрөл бүрийн нэхэмжлэл хариуцсан албад хэрэгжүүлдэг. Жишээлбэл, хариуцагчийн эд хөрөнгийг хураан авах ажиллагааг шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлэх бол, бусад нэхэмжлэлийг орон нутгийн шүүх хариуцдаг[1]

Албадлагын арга хэмжээгээр нь:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараагийн ялгаатай тал нь шийдвэрийг албадан хэрэгжүүлэх хүрээнд илэрдэг. Тухайлбал, Европын ихэнх оронд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүхэд хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны нэг хэсэг гэж үздэг тул үүнтэй уялдаад тухайн ажиллагааг шүүхийн үндсэн чиг үүрэгт тооцдог (Испани, Англи г.м.). Өөр нэг хувилбар нь иргэний хэргийн шүүхэд хэрэг хянан хэлэлцэх болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааг өөр хооронд нь маш нарийн заагладаг (Франц, Герман г.м.)[1].

Байгууллагын тогтолцоогоор нь:

Гурав дахь ялгаатай тал нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцооны хэлбэрээр илэрдэг (төрийн, хувийн ба холимог). Төрийн байгууллагын шийдвэр гүйцэтгэгчийг шүүхийн ба захиргааны гэж ялгана. Тухайлбал, Франц болон Шотланд, Португал, Нидерланд, Литва зэрэг улсад шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааг ихэвчлэн хувийн шийдвэр гүйцэтгэгч, төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлэх бөгөөд тэдгээр нь тогтолцооны хувьд шүүхэд харьяалагдана.

Тэгвэл төрийн шийдвэр гүйцэтгэх чиг үүрэгтэй байгууллагын хувьд, гол төлөв Австри, Испани, Дани зэрэг улс, тухайлбал, Испани Улсад шүүгч өөрийн гаргасан шийдвэрийг хариуцах бөгөөд гурав дахь этгээдийн мэдэлд байгаа хариуцагчийн эд хөрөнгийг хураан авах эрхтэй байдаг. Австри Улсад шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь, хэдийгээр шүүхийн эрх мэдэлд байдаг ч, гүйцэтгэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэгч хариуцдаг. Бүхэлдээ шүүхийн тогтолцооны хэлбэр давамгайлсан улс оронд нэхэмжлэлийг ёсчлон биелүүлэх чиг үүргийг гол төлөв хувийн шийдвэр гүйцэтгэгч, эсвэл шүүхийн байгууллагын алба хаагч хэрэгжүүлдэг.

---

[1] Хесс Б. Системы принудительного исполнения // Исполнительное производство:традиции и реформы. М. : Инфотропик, 2011. С. 57.

ХБНГУ болон Англизэрэгхолимог тогтолцоотой улс орны хувьд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг ихэвчлэн хувийн шийдвэр гүйцэтгэгч, эсвэл шүүхийн ажилтан хэрэгжүүлэх бол, гуравдагч этгээдийн мэдэлд байгаа эд хөрөнгийг хураан авах ажиллагааг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. Тухайлбал, ХБНГУ-д шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд тэрээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүхээс хараат бусаар биее даан хэрэгжүүлдэг.

Захиргааны гүйцэтгэлийн тогтолцооны хувьд шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхээс гадуур гүйцэтгэх засаглалын мэдэлд байдаг (Швед ба Финлянд). Тухайлбал, Швед Улсад шийдвэр гүйцэтгэх ажиллагааг биее даасан агентлаг хянах бол татварын нэхэмжлэлийг үндэсний татварын алба нь хариуцах бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь тус улсын Санхүүгийн яам хянадаг.

Дээрх ангилалд тулгуурлан үндэсний шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоо, түүний хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох боломжтой. Тухайлбал, уг ангиллаас үзэхэд нэг бүлэгт хамаарах улс орнуудын хувьд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо болон шүүхийн шийдвэр хэрэгжүүлэх арга барил өвөрмөц болох нь харагдаж байна. Түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхэд уг ажиллагааг зохион байгуулах ба шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ гэсэн үндсэн хоёр үзүүлэлтийг ач холбогдол өндөртэйд тооцдог.

Оросын Холбооны Улс:

Хууль сахиулагчийн үйл ажиллагаа нь Холбооны “Хууль сахиулах ажиллагааны тухай” 1997 оны 7-р сарын 21-ний өдрийн 118-ФЗ, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хууль, 1997 оны 7-р сарын 21-ний өдрийн 119-ФЗ “Хууль сахиулах ажиллагааны тухай” хууль батлагдсанаар эхэлсэн. Эдгээр хуулиуд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоог эрс өөрчилж, шийдвэр гүйцэтгэлийн биее даасан институтийг бий болгох эрх зүйн үндсийг бүрдүүлжээ.

Дээрх хуулиуд нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад иргэн, байгууллагын эрхийг хамгаалах, бэхжүүлэхэд тодорхой эерэг үр дүнд хүргэж байна.

ОХУ-ын Холбооны шийдвэр гүйцэтгэх албаны бүтэц:

- холбооны шийдвэр гүйцэтгэх албаны нутаг дэвсгэрийн байгууллага;

- холбооны шийдвэр гүйцэтгэх албаны нутаг дэвсгэрийн хэлтэс;

- холбооны шийдвэр гүйцэтгэх албаны нутаг дэвсгэрийн хэлтэс хоорондын алба;

- холбооны шийдвэр гүйцэтгэх албаны шийдвэр гүйцэтгэх тусгай хэлтсээс бүрддэг.

Шийдвэр гүйцэтгэх албаны чиг үүрэг:

Холбооны шийдвэр гүйцэтгэх алба нь гүйцэтгэх байгууллага бөгөөд шүүхээс гаргасан шийдвэр, хуульд заасан бусад байгууллага, албан тушаалтны шийдвэрийг гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэ алба нь үйл ажиллагаандаа Үндсэн хууль, холбооны хууль, Ерөнхийлөгч ба засгийн газрын акт, олон улсын гэрээ, хууль зүйн яамнаас гаргасан актуудыг удирдлага болгодог.

Шийдвэр гүйцэтгэх албаны үндсэн чиг үүрэг нь:

- Үндсэн хуулийн шүүх, дээд шүүх, харьяа болон арбитрын шүүхийн үйл ажиллагааны тогтоосон журмыг хангах;
- Харьяаллын болон арбитрын шүүхийн шийдвэр, түүнчлэн ОХУ-ын хууль тогтоомжид заасан бусад байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангах;
- Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангах;
- Шийдвэр гүйцэтгэх албаны нутаг дэвсгэрийн байгууллагыг удирдлагаар хангах;
- Улсын бүртгэлд оруулсан хугацаа хэтэрсэн өр төлбөрийг нөхөн төлүүлэхтэй холбогдсон хуулийн этгээдийн бүртгэлийн хэрэгжүүлэх.

Энэ хүрээнд дараах үйл ажиллагааг явуулдаг байна.Үүнд:

1. Шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны тайлан, мэдээ гаргах;
2. Шийдвэр гүйцэтгэх албаны зорилго, зорилт, үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх;
3. Харьяа нэгжид үүрэг даалгавар өгөх, төлөвлөгөө батлах;
4. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
5. Үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянах;
6. Авлигын эсрэг арга хэмжээ зохион байгуулах;
7. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах;
8. Олон улстай хамтын ажиллагааны гэрээ байгуулах;
9. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хамтын ажиллагааг зохион байгуулах;

10. Шийдвэр гүйцэтгэх алба онцгой нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, арилгах;

11. Төрийн хяналт, шалгалтын үүргийг гүйцэтгэдэг байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ-ын шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа нь дараах онцлогтой.

1. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх байгууллага нь шүүхэд харъяалагддаг боловч тусдаа шийдвэр гүйцэтгэх хэлтэстэй. Үүний зэрэгцээ, төлбөр төлөгчийн эд хөрөнгийг үнэлэх, зарах гэх мэт туслах чиг үүргийг өөр байгууллагуудад хуваарилдаг бөгөөд ингэснээр эдгээр үүргийг хамтран гүйцэтгэдэг;

2. Улс даяар өмчлөлийн үндсэн хэлбэрийг хамарсан цахим мөрдөн байцаах, хяналтын систем бий болсон. Энэхүү системээр дамжуулан шүүх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсний дараа хариуцагчийн үл хөдлөх хөрөнгө, банкны хадгаламж, хөрөнгийн менежментийн систем, тээврийн хэрэгсэл, үнэт цаас зэрэг эд хөдлөх хөрөнгийг хурдан олж, хянах боломжтой юм. Энэ нь төлбөр авагч, төлбөр төлөгчийн талаар мэдээлэл өгөх боломжгүй байсан ч гэсэн хэрэгжилтийг хангах чухал ач холбогдолтой юм.

3. Шүүхүүд шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн этгээдэд торгууль ногдуулдаг. Хятадад хүн бүр шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

4. Мэдээллийн технологийн хэрэгслийн тусламжтайгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хяналтыг бэхжүүлэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод үндэсний цахим платформыг бий болгосон.

Ийнхүү Хятадын шүүхүүд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ажлын болон удирдлагын загваруудын аль алинд нь шинэчлэл хийж, шүүхийн шийдвэрийг цаг тухайд нь биелүүлэх асуудлыг үр дүнтэй шийдвэрлэж чаджээ.

Хятадад шүүхүүд өөрсдөө эсвэл бусад шүүхийн гаргасан иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны иргэний нэхэмжлэлийн барьцааны дүгнэлт, шийдвэр, зуучлалын гэрээг хэрэгжүүлэх үүрэгтэй. Мөн арбитрын байгууллагаас гаргасан арбитрын шийдвэр, зарим захиргааны шийдвэр, нотариатаар гэрчлүүлсэн өр төлбөрийн хэрэгслүүд, шүүхээр хянан батлагдсан эвлэрлийн гэрээ, гадаадад гаргасан шүүх, иргэний болон арилжаа хэргийн

хэргийн шүүхийн шийдвэр, арбитрын шийдвэр зэрэг бусад хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичгүүдийг хариуцдаг.

Хятад улсын шүүхүүд орчин үеийн технологийн шинэчлэлийг ашиглаж шүүх ажиллагаа, хууль сахиулах, шүүхийн үйлчилгээ, шүүхийн ил тод байдал, шүүх засаглалын талаар дээр анхаарлаа төвлөрүүлж, аажмаар интернетэд суурилсан, ил тод, ухаалаг шүүх тогтолцоог бий болгож байна.

1. Хэрэг бүртгэх, хянах зорилгоор интернетэд суурилсан хууль сахиулах тогтолцоог бий болгох, хүн, эд хөрөнгийг хайх, хянах асуудлыг шийдвэрлэх;

Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх гол цөм нь эд хөрөнгө байдаг учир хариуцагчийн эд хөрөнгийг цаг тухайд нь үр дүнтэй олж тогтоох нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний алхам бөгөөд үүний урьдчилсан нөхцөл, түлхүүр юм. Мэдээллийн технологид суурилсан аргуудын тусламжтайгаар Хятад улсын шүүхүүд өмчийг таних аргыг шинэчилсэн. Мэдээллийн технологид суурилсан сүлжээ нь шүүх, засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллагуудтай хамтран өмчийн бүртгэлийн мэдээлэлд нэвтрэх, техникийн болон аюулгүй байдлын стандартыг нэгтгэх боломжийг олгодог ба бүх өмч хөрөнгийн бүх хэлбэрийг хамарсан хэрэг бүртгэлт, хяналт шалгалтын системийг бий болгосон явдал юм.

Одоогийн байдлаар Хятадын шүүхийн сүлжээ нь Нийгмийн аюулгүй байдлын яам, Байгаль орчны яам, Тээврийн яам, Ардын банк зэрэг 16 төрийн байгууллагатай, бусад банк, даатгалын компаниуд, банк бус санхүүгийн гээд 3,900 гаруй байгууллагуудтай хамтран ажилладаг. Улсын хэмжээнд үл хөдлөх хөрөнгө, банкны хадгаламж, санхүүгийн болон баялгийн бүтээгдэхүүн, усан онгоц, тээврийн хэрэгсэл, үнэт цаас, цахим хөрөнгө зэрэг 16 ангиллын 25 мэдээлэлд нэвтрэх эрхийг авсан бөгөөд ингэснээр шүүхүүд цахимаар бүртгэгдсэн үл хөдлөх хөрөнгийн бүх мэдээлэлд хурдан нэвтрэх боломжтой.

2. Хөрөнгийг захиран зарцуулах үр ашгийг дээшлүүлэх зорилгоор цахим үнэлгээ, дуудлага худалдааг бүх талаар хөнгөвчлөх

БНХАУ-д шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх явцад хариуцлагын бүх хөрөнгийн 60 орчим хувь нь нэхэмжлэгчид шууд шилжүүлэх боломжгүй газар, үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл, өмчлөл, оюуны өмч байдаг. Сүүлийн жилүүдэд, хятадын шүүхүүд хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг цахимжуулах ажлыг бүх талаар нь хялбаршуулж байна.

Нэгдүгээрт, цахим лавлах системийг ажиллуулсан. Хөрөнгийн үнэлгээний уламжлалт аргыг хадгалан үлдэх явцдаа өөр арга жишээлбэл,

холбогдох талуудын хооронд үнийн хэлэлцээр хийх, зорилтот лавлагаа, цахим лавлагаа авах аргыг ашигладаг. Шийдвэр гүйцэтгэгч дуудлага худалдаагаар эд хөрөнгийг зарах тохиолдолд холбогдох талууд эхлэх үнийн талаар тохиролцож болно. Хэрэв зөвшилцөлд хүрч чадахгүй бол дуудлага худалдаагаар зарагдах эд хөрөнгийн зах зээлийн үнийн талаар холбогдох байгууллагуудтай зөвлөлдөнө. Хэрэв эхлэх үнийг дээр дурдсан хоёр аргаар шийдэх боломжгүй бол шийдвэр гүйцэтгэгч цахим лавлагаа системд нэвтэрч, үл хөдлөх хөрөнгийн байршил, давхарын дугаар, хэмжээ, чиглэл эсвэл тухайн загварын жил гэх мэт бүхий л мэдээлэлд нэвтэрнэ. Ингэснээр систем мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хэдэн минутын дотор лавлагаа үнэ авна. Энэхүү систем нь урт хугацааны үнэлгээ, өртөг өндөр, татан буулгах үр ашиг багатай гэх мэт хөрөнгийн татан буугдахад тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн тус дэм болдог.

Хоёрдугаарт, Дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулж байна. Эд хөрөнгө цахим дуудлага худалдаагаар зарах, төлбөр хийх, үнэ хаялцуулах, гүйлгээг баталгаажуулах гэх мэт уламжлалт арга хэмжээнд оролцдог бүх үйл ажиллагааг цахим дээр явуулдаг. Цахим дуудлага худалдааны давуу тал нь:

- Олон нийтэд нээлттэй, оролцоог жигд хангах
- Мэдээллийн нээлттэй байдал
- Хэрэглэхэд хялбар, оролцоог хангах
- Дуудлага худалдаагаар зарах өртөг бага

3. Хуулийн хэрэгжилтийн нээлттэй байдал, практикийн ил тод байдлыг сайжруулах

БНХАУ-ын дээд шүүх нь “Хяналтын тухай мэдээллийг нээлттэй болгох” вэбсайттай болсон. Үүний дагуу холбогдох тал болон олон нийт хууль сахиулахтай холбоотой бүх мэдээллийг нээлттэй, бүхий л сувгаар авах боломжтой

4. Хэрэгжүүлэх удирдлагын менежментийг өөрчлөхийн тулд удирдлагын нэгдсэн сүлжээ байгуулах

Сүүлийн жилүүдэд, хяналтын зөвлөлийн дэмжлэгтэйгээр Хятад улсын шүүхүүдэд “нэгдсэн удирдлага, зохицуулалтын хамтын ажиллагаа, нэгдсэн тушаал”-ыг агуулсан хэрэгжилтийн удирдлагын шинэ загварыг өөрчилж, мэдээллийн технологид суурилсан удирдлагыг бий болгосон. Энэхүү системд шүүхийг дөрвөн түвшинд нэгтгэж, хэрэгжилтийг зохицуулах, хөрөнгө, хөрөнгийн менежмент, онцгой байдлын команд, алсын уулзалт, зөвлөгөөн,

гомдол, өргөдөл, чанар, хяналт, гүйцэтгэлийн үнэлгээ зэрэг 20 гаруй чиг үүрэгтэй гүйцэтгэх тушаал, удирдлагын сүлжээг ажиллуулсан байна.

Бүгд Найрамдах Солонгос Улс:

Бие даасан захиргааны шүүх захиргааны байгууллагын хууль бус үйлдлээс иргэнд үүссэн хохирлыг барагдуулж, иргэний эрхийг сэргээх зорилгоор захиргааны шүүх үйл ажиллагаагаа явуулна.

Захиргааны шүүхийн үйл ажиллагааны онцлог нь эрх зүйн асуудлаар маргаж байгаа талаасаа иргэний шүүх ажиллагаатай адил боловч ЗХХШтХ-д өөрөөр заагаагүй бол ИХШХШ-ийн дагуу шийдвэрлэхээр заасан нь онцлог юм. Өөрөөр хэлбэл иргэн, хуулийн этгээд болон захиргааны байгууллагын хооронд хийсэн “гэрээ”-ний хүрээнд үүссэн талуудын маргааныг шүүхийн байгууламжийн тухай хууль болон ИХШХШтХ-ийн дагуу шийдвэрлэдэг (ЗХХШтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2). Гэрээний бус захиргааны үйлчлэлээс үүссэн хэрэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийхгүй. Учир нь захиргааны байгууллага өөрөө захиргааны акт үйлдэн тухайн актын хэрэгжилтийг хангахын тулд албадан гүйцэтгэх эрхтэй.

Захиргааны байгууллага, иргэн хоёрын хооронд үүссэн маргааныг захиргааны шүүхээр шийдвэрлээд захиргааны акт хууль зөрчөөгүй гэж үзвэл захиргааны байгууллага тухайн актын хэрэгжилтийг хангахын тулд захиргааны албадлагын арга хэмжээг авна. Харин эсрэгээрээ захиргааны акт хууль зөрчсөн гэсэн шүүхийн шийдвэр гарвал захиргааны байгууллага тухайн актыг хүчингүй болгон тухайн актын үйлчлэлээс иргэнд үүссэн хохирлыг иргэний шүүхээр шийдвэрлэж иргэний хохирлыг барагдуулна.

Захиргааны байгууллагын дараах 5 албадлагын арга хэмжээг авна. Үүнд:

- Төлөөлөн гүйцэтгэх: Үүрэг хүлээгч захиргааны үйлчлэлтэй холбогдох ямарваа нэгэн үүргээ эс гүйцэтгэж хуульд заасан бусад албадлагын аргыг хэрэглэх боломжгүй тохиолдолд гуравдагч этгээд болох бусад хуулийн этгээдэд даалгаж болно. Гуравдагч этгээдийн ажлын хөлсийг үүрэг хүлээгч хариуцна. Захиргааны байгууллага нь “Орон нутгийн тухай хууль”-н 168 дугаар зүйлд заасны дагуу орон нутгийн удирдах байгууллага, орон нутгийн байгууллагын удирдагч нь өөрийн харьяалан гүйцэтгэх ажлын хэсгийг орон нутгийн удирдах байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээ байгуулан даалгаж болно. Уг гэрээг нийтэд ил тод зарлана.

- Торгууль ногдуулах: Үүрэг хүлээгч захиргааны хуулийн дагуу үүргээ эс биелүүлэх тохиолдолд тодорхой хугацаа олгон, тухайн хугацаанд гүйцэтгэхгүй бол торгуулийн арга хэмжээ авна.

- Шууд албадлага: Үүрэг хүлээгч захиргааны хуулийн дагуу үүргээ эс биелүүлэх тохиолдолд захиргааны байгууллага үүрэг хүлээгчийн биед болон эд хөрөнгөд халдаж тухай үүргийн гүйцэтгэлийг хангана.

- Татварын албадлага (compulsory collection): Үүрэг хүлээгч нь захиргааны холбогдолтой мөнгөн төлбөрийг төлөхгүй тохиолдолд үүрэг хүлээгчийн эд хөрөнгөд халдан үүргийн гүйцэтгэлийг хангана.

- Immediate compulsion: захиргааны үйл ажиллагаанд шууд нөлөөлж саад учруулсан дараах тохиолдолд захиргааны байгууллага ард иргэдийн бие, эд хөрөнгөд халдан захиргааны зорилгыг биелүүлнэ.

• Захиргааны байгууллага урьдчилан мэдэгдэх боломжгүй байсан.

• Тухайн үүргийн гүйцэтгэлийг захиргааны акт гаргаснаар биелүүлэх боломжгүй байсан.

Гэхдээ захиргааны байгууллага захиргааны шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүйй тохиолдолд ЗХХШтХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу захиргааны анхан шатны шүүх тодорхой хугацааны дотор шүүхийн шийдвэрийг эс гүйцэтгэвэл шүүхийн шийдвэр гүйцэтгээгүй хугацаанд үүссэн иргэний хохирлыг барагдуулах тогтоол гаргадаг бөгөөд харин БНСУ-д захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэж тусдаа бие даасан тогтолцоо байхгүй байна.

Америкийн Нэгдсэн Улс:

АНУ-ын бүх шатны шүүх нь иргэний болон эрүүгийн хэргийн аль алиныг нь шийдвэрлэдэг. Шүүгчид эрүү, эсхүл иргэний чиглэлээр мэргэшдэггүй ба шүүхийн өмнө хүлээгдэж буй бүх хэргийг шийдвэрлэдэг. Үүнтэй адилаар шүүхийн шийдвэрийг гүйцэтгэж байгаа ажилтнууд, түүний дотор эд хөрөнгийг хураан авах ажилтнууд эрүүгийн болон иргэний хэргийн аль алинд нь оролцдог байна.

АНУ-ын муж бүр өөрийн гэсэн шүүх системтэй бөгөөд муж улсын хууль тогтоомжоос хамаарч шүүхийн баримт бичгийн нэр, төрөл, эд хөрөнгөтэй холбоотой журам, хураан авах байдал нь янз бүр, нэлээд ялгаатай. Жишээлбэл, зарим муж улсад гүйцэтгэх баримт бичгийг гэр бүлийн аль ч гишүүнд гаргаж өгдөг бол зарим мужид зөвхөн өөрт нь биечлэн өгдөг.

АНУ-ын шийдвэр гүйцэтгэх байгууллагын зохион байгуулалт нь:

1. Маршалын алба;

2. Шериф ба тэдгээрийн орлогч;

3. Хувийн агентлаг.

АНУ-д шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиг үүргийг шериф, тэдний орлогч нар гүйцэтгэдэг, маршалын алба нь холбооны түвшинд, хувийн агентлагууд гүйцэтгэгддэг. Маршал бол Холбооны шүүхийн системийн албан тушаалтан бөгөөд АНУ-ын Хууль зүйн яамаар дамжуулан АНУ-ын Ерөнхий прокурорт үйл ажиллагаагаа тайлагнадаг байна.

АНУ-ын Маршалын алба нь Хууль зүйн яамны харьяа холбооны байгууллага юм. Маршалын алба нь АНУ-ын холбооны гүйцэтгэх засаглал ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсэг юм. АНУ-ын маршалууд нь шүүгч, шүүхийн барилгыг хамгаалах ажиллагааг хариуцдаг. Маршалын алба нь АНУ-ын нэрийн өмнөөс гаргасан бүх хууль ёсны захиалга, журам, тушаалыг гүйцэтгэж, холбооны засгийн газраас цалин авдаг. АНУ-ын хэмжээнд 94 маршал, 4000 гаруй ажилчидтай.

Шериф бол муж улсын хамгийн дээд хууль сахиулах ажилтан ба ихэнх тохиолдолд мужийн хүн амаас сонгодог. Цагдаагийн даргыг сонгох улс төрийн үйл явц нь Америкийн бараг л өвөрмөц уламжлал юм. Шерифын төлөө ажилладаг тангараг өргөсөн хууль сахиулагчийг “орлогч дарга” буюу “офицер” гэж нэрлэдэг бөгөөд шерифын үүргийг гүйцэтгэх эрх бүхий алба хаагч юм.

Шүүгч зарлан дуудах болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх мэдэгдлийг өөрсдийн мужийн шерифээр дамжуулж хүргүүлдэг байсныг АНУ-ын хотууд томрохын хэрээр орон нутгийн шерифүүдэд шүүхийн бичиг баримтыг хүргэх нь туйлын хэцүү ажил болж цаг хугацаа алдах болсон байна, иймээс цаг тухайд нь хүргэх шалтгаанаар хувийн агентлаг байгуулагдсан. Хувийн агентлаг нь мужийн эрх зүйн зохицуулалтаасаа хамааран өөр өөр байдаг.

АНУ-д төлбөр төлөгчийн хөрөнгийг хайх ажлыг өмгөөлөгчид гүйцэтгэдэг бөгөөд тэд өмчийг олох албан ёсны (жишээлбэл, шүүх, зээлийн агентлагийн хүсэлтээр) болон албан бус (жишээ нь хувийн мөрдөгчөөр дамжуулан) хэлбэрээр ашигладаг.

Тус улс нь Холбооны тогтолцоотой улс болохын хувьд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг холбооны түвшинд Холбооны нутаг дэвсгэрийн шүүх хэрэгжүүлдэг. Үүнтэй уялдаад шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тус улсын муж тус бүр өөрийн хууль тогтоомжид нийцүүлэн

өвөрмөц арга барилаар хэрэгжүүлдэг. Гэхдээ уг ажиллагааны явцад муж тус бүр гаргасан шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрөх зарчмыг хатуу баримталдаг. Тухайлбал, хэрэв тухайн иргэний хэрэг аль нэг мужид хянан хэлэлцэх ёстой байсан харин түүний эд хөрөнгө өөр мужид байгаа тохиолдолд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг үндэслэн тухайн эд хөрөнгийг эзэмших, захиран зарцуулах эрхтэй болсон муж, нөгөө мужийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх эрхтэй байдаг.

Түүнчлэн тус улсын хууль тогтоомжоор хэргийн төрлөөс хамааран шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны арга барил харилцан адилгүй байдаг. Учирсан хохирлыг биет байдлаар нөхөн төлүүлэхээр болсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн хуудас заавал шаардана.

Нэхэмжлэгчийн шаардлагыг сайн дурын ба шүүхийн шийдвэрээр гэсэн хоёр үндсэн аргаар биелүүлдэг[1].

Зарим мужид шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хувийн шийдвэр гүйцэтгэгч болон Маршалын алба, эсвэл цагдаагийн байгууллага хэрэгжүүлж болохоор хуульчилсан байдаг.

Англи:

Засаг захиргааны тогтолцооны хувьд хэдийгээр АНУ-тай төстэй боловч шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэд хэдэн ялгаатай тал бий. Тухайлбал, Англи Улсын шүүхийн тогтолцоонд, гол төлөв, уламжлалт хэлбэр давамгайлсан байдаг бол АНУ-ын хувьд бие даасан шинжтэй, эрх зүйн хувьд онцлог механизмыг бүрдүүлсэн байдаг тул шүүхийн байгууллага нь, мөн үүнтэй уялдсан өвөрмөц тогтолцоотой байдаг.

Англид шийдвэр гүйцэтгэх ажиллагааг орон нутгийн шүүхээс гадна Улсын Дээд Шүүх хэрэгжүүлэх эрхтэй. Гэхдээ уг ажиллагааг Дээд шүүхийг бодвол орон нутгийн шүүхэд илүү хялбар журмаар явуулдаг. Үүнээс гадна Улсын Дээд шүүхэд нэхэмжлэгч болон хариуцагч тал тогтсон тарифаар төлбөр хураамж төлдөг бол мужийн буюу орон нутгийн шүүхэд ямар нэгэн хураамж төлдөггүй.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэхэмжлэлийн зүйлд, гол төлөв, эд хөрөнгө, бэлэн мөнгө болон газар байдаг.

Франц Улс:

---

[1] Бажин, И.Г. Система образования программ профессиональной переподготовки и приема на работу государственных служащих / И.Г. Бажин // Государственная служба. - 2010. -№ 10 - 15-19 с.

Франц нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тогтолцоог анх XVI зуунд бүрдүүлсэн оронд тооцогддог. Өнөөдөр тус улсад шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах субъектууд гардан хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч;

2. Улсын Ерөнхий прокурор;

3. Холбооны улсын прокурор;

4. Цагдаагийн байгууллагын алба хаагч (удирдах албан тушаалтан болон офицерийн бүрэлдэхүүн).

Эдгээр субъект дотроос шүүхийн шийдвэр гүйцэтгэгч гол чиг үүргийг хэрэгжүүлдэг тул түүнд, мөн өндөр шаардлага тавигддаг. Тухайлбал, эрх зүйн дээд боловсролтой, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 2 ба түүнээс жил ажилласан, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх г.м. Шийдвэр гүйцэтгэгчийг сургалтын тусгайлсан хөтөлбөрөөр 5 жилийн хугацаатай бэлтгэх бөгөөд төгсөгчдөөс мэргэжлийн чиглэлээр улсын шалгалт авч, диплом олгодог.

Түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийг тус улсын Хууль зүйн сайдын тушаалаар томилох бөгөөд тэрээр томилогдсон газрын шүүхэд тангараг өргөх үүрэгтэй.

Зохион байгуулалтын хувьд шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоог доод түвшний хэрэгжүүлэгч байгууллага болох бүс нутгийн танхимын болон департмент (тус улсын Засаг захиргаа-нутаг дэвсгэрийн тойрог)-ын нийгэмлэгийн төлөөлөгчдөөс бүтсэн гурван түвшинд хуваадаг. Удирдлага, зохион байгуулалтын хувьд эдгээрийг Үндэсний танхим толгойлох бөгөөд тэргүүн нь ерөнхийлөгч бөгөөд, түүний удирдлагад орлогч, нягтлан бодогч, шийдвэр гаргах эрхтэй товчоо ажиллана. Эдгээрийн дор давж заалдах шатны шүүх байх ба түүний шийдвэр гүйцэтгэгч нь Бүсийн танхимын түвшинд нэгдэнэ. Анхан шатны буюу доод түвшинд нутаг дэвсгэрийн захиргааны нийгэмлэг байна.

Доод шатны шүүхийн хувьд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хотын болон орон нутгийн хүрээнд хэрэгжүүлнэ. Түүний эрх мэдэлд шүүхийн хэрэг нээх, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, шүүхийн тэмдэглэл хөтлөх, шүүхийн шийдвэр гаргах нэхэмжлэгч болон болон үл хөдлөх хөрөнгөөс бусад эд хөрөнгийг олж тогтоох зэрэг ажиллагаа багтана.

Дүгнэлт

Гадаадын зарим орны жишгийг судлан үзэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэдэг дараах үндсэн хэлбэртэй байна. Үүнд:

1.Шүүхийн харьяаны эсхүл тусгайлан хуулиар эрх олгогдсон төрийн байгууллага гүйцэтгэдэг. Дээрх тогтолцоотой улс орнуудын онцлог нь:

- шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоонд байж, шүүгч өөрийн гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьдаг, гүйцэтгэлийг нь зарим тохиолдолд өөрчлөх, эсхүл албадлага хэрэглэхэд биечлэн оролцдог байх

- хуулиар тусгайлан эрх олгосон албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэгч, цэрэгжүүлсэн байгууллага шийдвэрийг гүйцэтгэдэг

2. Төрийн болон хувийн байгууллага байх холимог тогтолцоо:

- иргэд болон хуулийн этгээдийн хоорондын эд хөрөнгийн шинжтэй шийдвэрийг хувийн шийдвэр гүйцэтгэх систем хэрэгжүүлдэг.

- хүүхдийн тэтгэлэг, эрүүгийн хэргийн хохирол, төрийн нэхэмжлэл зэрэг шийдвэрийг төрийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлдэг.

3. Хувийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоо:

-Эрх зүйн системээсээ хамаарч өөр өөр байх ба иргэдийн өр төлбөр, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг хоорондын зуучлалын системээр хэрэгжүүлдэг онцлогтой байна.

Манай орны тухайд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүхийн харьяанд шилжүүлснээр шүүх өөрийн гаргасан шийдвэрээ эргэн хянах, гүйцэтгээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэдэг тогтолцоо бий болох боломжтой гэж үзлээ.

Гадаад орнуудын шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяаллын жишиг нь шүүхийн харьяа, төр-хувийн байгууллагын холимог, хууль сахиулах байгууллага, хувийн байгууллага гүйцэтгэх зэрэг олон төрөлтэй байх тул манай орон дэлхий нийтийн чиг хандлагыг харгалзан өөрийн орны тохирсон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяаллыг бий болгох шаардлага байна гэж үзлээ.

--o0o---